Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 255 дугаар тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 4 дүгээр хавсралт маягт 2

Хагас жил, улирлын үйл ажиллагааны тайлан /маягт 2/	
Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.	
Тайлагнах хугацаа /Жишээ нь: 2020 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 3 дугаар сарын 31-ний өдөр/	2025 оны II улирал *(2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдөр)*
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	Нэр: Ард Кредит ББСБ ХК, УБД: 9010002003, ҮЦК: ADB, Утасны дугаар: +976 77003322
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын Хөрөнгийн Бирж
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Банк бус санхүүгийн байгууллага
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	364,000,000 (Гурван зуун жаран дөрвөн сая) ширхэг
Улирлын тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Бэлтгэсэн: ТУЗ Нарийн бичгийн дарга Г.Есү-Үжин Хянаж, баталсан: Гүйцэтгэх захирал Г.Сүхбаатар
1.	*Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/*
Санхүүгийн байдлын үзүүлэлт	2025 оны эхний хагас жилийн байдлаар нийт актив 122.9 тэрбум төгрөг, үүнээс нийт зээлийн багц 71.6 тэрбум байгаа бол нийт эздийн өмч 35.6 тэрбум төгрөг, нийт өр төлбөр 87.3 тэрбум төгрөг байна.
Орлогын тайлан	2025 оны эхний хагас жилд өссөн дүнгээр хүүгийн орлого 10.1 тэрбум төгрөг, хүүгийн зардал 6.8 тэрбум төгрөг, хүүгийн бус орлого 7.8 тэрбум, бусад үйл ажиллагааны орлого 3.0 тэрбум төгрөгт хүрч өссөн бол хүүгийн бус зардал 5.7 тэрбум, эрсдэлийн сангийн зардал 6.2 тэрбум, бусад үйл ажиллагааны зардал 202 сая, орлогын албан татварын зардал 315 сая төгрөг байна. Улмаар эхний хагас жилд 1.7 тэрбум төгрөгийн ашигтай ажиллав
Өмчийн өөрчлөлтийн тайлан	Тайлант хугацаанд цэвэр ашиг 1.7 тэрбумаар нэмэгдэж, хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл данс 3.1 тэрбумаар буурснаар тайлант хугацааны эхэнд өөрийн хөрөнгө 37.0 тэрбумаас 1.4 тэрбумаар буурч 35.6 тэрбумд хүрэв.

	Мөнгөн гүйлгээний тайлан	Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 7.1 тэрбум төгрөг, эцсийн үлдэгдэл 7.5 тэрбум төгрөг байна. Тайлант хугацаанд 84.5 тэрбумын зээл олгож, 78.3 тэрбум төгрөгийн үндсэн зээлийн эргэн төлөлт хийгджээ.
2.	*Хагас жилийн болон улирлын санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт*	
	Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Аудитын хороо 2025 оны 7 сарын 23-ны өдрийн хуралдаанаар хагас жилийн санхүүгийн тайланг танилцуулан хэлэлцүүлэхээр бэлтгээд байна.	
3.	*Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт*	
3.1.	*Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/*	Цэвэр ашгийн хувь: 8.4% Өөрийн хөрөнгийн өгөөж: 12.5% Нийт хөрөнгийн өгөөж: 3.9%
3.2.	*Хөрвөх чадвар болон санхүүгий нөөц, боломжийн үзүүлэлт*	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 13.3% Өр болон өөрийн хөрөнгийн харьцаа (D/E) 1.9 Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 29.0%
3.3.	*Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл*	1. 2025 оны 2 дугаар сарын 21-ний өдөр "Хувьцаа эзэмшигчдэд нээлттэй өдөрлөг"-ийг амжилттай зохион байгууллаа. Тус өдөрлөгөөр компанийн үйл ажиллагаа, санхүүгийн тайлангийн мэдээллийг олон нийтэд ил тод танилцуулж, цаашдын зорилт, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хувьцаа эзэмшигчдэд танилцуулав. 2. Ард Кредит ББСБ ХК нь Монголын анхны хосолсон кредит скорингийн системийг үйл ажиллагаанд нэвтрүүлэв. 3. Залуу бизнес эрхлэгчдийг дэмжих зээлийг үйлчилгээнд шинээр нэвтрүүлж Ард аппаар авах боломжтой болов. 4. Харилцагч нартаа үйл ажиллагаагаа хүртээмжтэй түгээх зорилгоор Дархан, Сэлэнгэ, Булган, Эрдэнэт, Хэнтий, Багануур, Сайншанд, Чойрт ажиллалаа.

5. Компанийн засаглалын кодексийн хэрэгжүүлэгч ТОП-20 нээлттэй компанийн нэгээр 3 жил дараалж шалгарав.



6. Royal Enfield Himalayan мотоциклийн зээлийг Ард Аппаас авах боломжтой боллоо.

7. Монголын шинэ үеийн инженерүүдийн мэдлэг боловсрол, технологийн салбарын хөгжлийн төлөө, залуусыг дэмжих, нийгмийн хариуцлагын хүрээнд MEF Youth 2025, DevSummit 2025 | The AI Generation арга хэмжээнд ивээн тэтгэгч, хамтрагчаар оролцов.

8. Онлайнаар зээл хаасан, зээлийн гэрээ цуцалсан тодорхойлолтыг авах боломжтой болов.

3.4.	*Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого*	Тухайн тайланд хугацаанд тэнцлийн гадуур зээлийн эрсдэлийн сангаас хаасан зээлийн үлдэгдэл 405.7 сая төгрөг, хүү хуримтлуулж тооцохыг зогсоосон зээлийн үлдэгдэл 299.7 сая төгрөг байна.
4.	*Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/*	

Их хэмжээний хэлцэл: Тайлант хугацаанд их хэмжээний хэлцэл хийгдээгүй болно.
Тайлант хугацаанд дараах сонирхлын зөрчилтэй хэлцлүүд хийгдсэн. Үүнд:

№	ТУЗ-ийн тогтоолын огноо	ТУЗ-ийн тогтоолын дугаар	Компанийн холбогдох этгээд /Нэгдмэл сонирхолтой этгээд	Активын хэлбэр	Дүн / Өөрийн хөрөнгийн эзлэх хувь
1	2025.01.06	2025/01	Компанийн холбогдох этгээд	Зээл/барьцааны гэрээ	0.09%
2	2025.01.07	2025/02	Компанийн нэгдмэл сонирхолтой этгээд	Зээл/барьцааны гэрээ	0.84%
3	2025.01.14	2025/4	Нэгдлийн оролцогч компани	Хувьцаа худалдан авах тухай	1.63%
4	2025.01.14	2025/05	Нэгдлийн оролцогч компани	Хөрөнгө оруулалт хийх тухай	0.81%
5	2025.01.20	2025/07	Нэгдлийн оролцогч компани	Зээл/барьцааны гэрээ	2.81%
6	2025.01.28	2025/08	Нэгдлийн оролцогч компани	Зээл/барьцааны гэрээ	0.05%
7	2025.02.26	2025/13	Нэгдлийн оролцогч компани	Үл хөдлөх хөрөнгө худалдах тухай	-
8	2025.02.27	2025/16-1	Нэгдлийн оролцогч компани	Үл хөдлөх хөрөнгө худалдан авах тухай	-
9	2025.02.27	2025/16-2	Нэгдлийн оролцогч компани	Зээл/барьцааны гэрээ	1.47%
10	2025.03.11	2025/17-1	Нэгдлийн оролцогч компани	Автомашин худалдах тухай	-

11	2025.03.25	2025/19	Компанийн эрх бүхий албан тушаалтан	Зээл/барьцааны гэрээ	0.14%
12	2025.04.03	2025/20	Компанийн эрх бүхий албан тушаалтан	Зээл/барьцааны гэрээ	0.45%
13	2025.04.07	2025/21	Компанийн эрх бүхий албан тушаалтан	Зээл/барьцааны гэрээ	0.17%
14	2025.04.17	2025/22	Компанийн эрх бүхий албан тушаалтан	Зээл/барьцааны гэрээ	0.53%
15	2025.04.24	2025/25	Нэгдлийн оролцогч компани	Зээл/барьцааны гэрээ	0.91%
16	2025.04.24	2025/26	Компанийн нэгдмэл сонирхолтой этгээд	Зээл/барьцааны гэрээ	0.05%
17	2025.04.30	2025/27	Компанийн эрх бүхий албан тушаалтан	Зээл/барьцааны гэрээ	0.06%
18	2025.05.21	2025/28-1	Нэгдлийн оролцогч компани	Зээл/барьцааны гэрээ	1.79%
19	2025.06.25	2025/31	Нэгдлийн оролцогч компани	Зээл/барьцааны гэрээ	8.98%

* Банк бус санхүүгийн байгууллагын холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны нийлбэр дүнгийн зохистой харьцаа 25 хувиас хэтрэхгүй.

5. *Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл*

Тус тайлангийн хугацаанд Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргаагүй.

6. *Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл*

Ард Кредит ББСБ ХК нь Монголын Хөрөнгийн биржийн 1 ангилалд бүртгэлтэй нээлттэй хувьцаат компанийн хувьд Компанийн тухай хууль, Компанийн засаглалын кодекс, олон улсын сайн туршлагаас суралцан компанийнхаа засаглалыг тасралтгүй сайжруулж, хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчид, хамтран ажиллагч байгууллагууддаа нээлттэй ил тод, чөлөөтэй байх зарчимыг баримталж ирсэн билээ.

Хувьцаа эзэмшигчдийн хурал

Компанийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байдаг бөгөөд хувьцаа эзэмшигчид нь ээлжит болон ээлжит бус хуралдаанаар дамжуулан эрхээ хэрэгжүүлжүүлдэг билээ.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал Ард Кредит ББСБ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу жилд нэгээс доошгүй удаа зарлан хуралдуулдаг бөгөөд 2025 оны ээлжит хурлыг 2025 оны 4 сарын 28-ний өдрийн 11.00 цагт, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 хороо, Сүхбаатарын талбай-2, Сэнтрал Тауэр 17 давхарт болон цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулсан. Хувьцаа эзэмшигчдийн энэ удаагийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хувьцаа эзэмшигчдэд танилцууллаа.

Хурлаар танилцуулсан асуудал:
1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах;
2. Компанийн 2024 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах;
3. 2024 оны ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланг танилцуулах;
4. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;
5. Ногдол ашиг хуваарилах эсэх тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн шийдвэрийг танилцуулах;
6. ТУЗ-ийн 2025 оны зардлын төсвийг танилцуулах;
7. Ард Кредит ББСБ ХК-ийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах;

Хурлаас гарсан шийдвэр:
Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах

Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг 99.96 хувийн саналаар батлав.
"Ард Кредит ББСБ" ХК-ийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, дүрмийн шинэчилсэн найруулгыг батлав.

Хурлаас гарсан шийдвэрийг Монголын Хөрөнгийн биржийн сайт дээрх Ард Кредит ББСБ ХК-ийн хурлын шийдвэрүүд хэсгээс харна уу.

Хувьцаа эзэмшигчдийн бүтэц

Хувьцаа эзэмшигчийн нэр	Тоо ширхэг	Хувь эзэмшил
Ард Санхүүгийн Нэгдэл ХК	153,588,654	42.19%
Ардын Тэтгэврийн данс ХХК	28,128,478	7.73%
С.Гэрэлтуяа	27,305,402	7.50%
Ард Лизинг ХХК	22,506,257	6.18%
Олон нийт	129,248,643	35.51%
Халаасны хувьцааны тоо	3,222,566	0.89%
Нийт хувьцааны тоо ширхэг	364,000,000	100.00%

Төлөөлөн Удирдах Зөвлөл

Ард Кредит ББСБ ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид ТУЗ гэх) нь Компанийн тухай хууль болон компанийн дүрэмд зааснаар ердийн 6 гишүүн, хараат бус 3 гишүүн нийт 9 бүрэлдэхүүнтэй. Компанийн Засаглалын Кодексын хэрэгжилтийг хангуулан ТУЗ-ийн гишүүдийн гуравны нэгээс доошгүй нэг хүйсийн гишүүдтэй байх зарчимыг баримтлан Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт Компанийг ерөнхий удирдлагаар ханган ажиллаж байна.

ТУЗ-ийн дарга:
Ч.Ганзориг, Гүйцэтгэх захирал, Айдакс ХХК
Ажлын туршлага: Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр 15 жил.

ТУЗ-ийн хараат бус гишүүд:

- **В.Ганзориг,** ТУЗ-ийн дарга, Бат Солюшн Партнерс
  Мэргэжил: Удирдлага, манлайлал, өөрчлөлтийн менежмент, цахим бизнесийн удирдлага,
  Ажлын туршлага: Банк санхүү, цахим хэвлэл, мэдээллийн салбарт удирдлагаар 20 жил ажилласан.
- **Б.Солонго,** Гүйцэтгэх захирал, Триквест ХХК
  Мэргэжил: Санхүүч, Бизнес удирдлага.
  Ажлын туршлага: Худалдаа, маркетингийн салбарт удирдлагаар 14 жил ажилласан.
- **С.Энхчимэг,** Гүйцэтгэх захирал, Бипрос Монголиа
  Мэргэжил: Зохион бүтээгч, инженер, бизнесийн удирдлага
  Ажлын туршлага: Сошиал медиа зөвлөх, бизнес хөгжүүлэлт, уул уурхайн салбарт 16 жил ажилласан.

ТУЗ-ийн Ердийн гишүүд:

- **О.Одбаяр,** ТУЗ-ийн дарга, Ард Даатгал ХК
  Мэргэжил: Эдийн засагч, нийгэм, Бизнесийн удирдлдага
  Ажлын туршлага: Эдийн засаг, бизнесийн салбарт удирдлагаар 25 жил ажилласан.
- **Б.Золбоо,** Гүйцэтгэх захирал, Ард Санхүүгийн Нэгдэл ХК
  Мэргэжил: Санхүү, эдийн засаг, нягтлан бодох бүртгэл.
  Ажлын туршлага: Хөрөнгө оруулалт, корпорацын санхүү, даатгал, финтекийн чиглэлээр 9 жил ажилласан.
- **Г.Уянга,** Гүйцэтгэх захирал, Ард Пропертиз ХХК
  Мэргэжил: Банк санхүүч .
  Ажлын туршлага: Банк санхүү, үл хөдлөх хөрөнгийн салбарт удирдлагаар 16 жил ажилласан.
- **Г.Сүхбаатар,** Гүйцэтгэх захирал Ард Кредит ББСБ ХК

Мэргэжил: Нягтлан бодогч, бизнесийн удирдлага.
Ажлын туршлага: Банк, банк бус санхүүгийн салбарт 20 жил ажилласан.

- **М.Мөнх-Эрдэнэ, Аудит Эрхэлсэн захирал, Ард Санхүүгийн Нэгдэл ХК**
  Мэргэжил: Банкны эдийн засагч, нягтлан бодогч, санхүүгийн удирдлага.
  Ажлын туршлага: Мэргэшсэн нягтлан бодогч, аудитаар 15 жил ажилласан.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын үйл ажиллагаа

Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлд заасны дагуу ТУЗ нь тодорхой асуудал эрхэлсэн байнгын болон түр хороодыг байгуулан ажиллуулдаг. ТУЗ-ийн дэргэдэх хороод тус бүрийн чиг үүрэг, үйл ажиллагаа, бүтэц бүрэлдэхүүн, гишүүдийн эрх үүрэг, тэдгээрт тавигдах шаардлага зэрэг бусад асуудлыг хороодын үйл ажиллагааны журам болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар зохицуулдаг.

ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнийг Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.2 дахь хэсэг, СЗХ-оос баталсан "Компанийн засаглалын кодекс"-т тус тус нийцүүлэн ТУЗ-ийн 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 2024/71 тоот тогтоолын дагуу шинэчлэн тогтоосон.

№	ТУЗ-ийн дэргэдэх хороод	Хорооны дарга	Хорооны гишүүд	Тайлант хугацаан дахь хурлын тоо
1	Аудитын Хороо	В.Ганзориг	М.Мөнх-Эрдэнэ, С.Энхчимэг	Ээлжит 1
2	Санхүү, Эрсдэл, Зээлийн хороо	О.Одбаяр	Б.Золбоо, Г.Сүхбаатар	Ээлжит 2
3	Засаглал, Нэр дэвшүүлэх хороо	Б.Солонго	Г.Уянга, Б.Золбоо	Ээлжит 1
4	Цалин урамшууллын хороо	С.Энхчимэг	Ч.Ганзориг, Б.Солонго	Ээлжит 1

Тайлант хугацаанд Төлөөлөн Удирдах Зөвлөл (ТУЗ) нийт 42 тогтоол баталсан бөгөөд эдгээр нь компанийн үйл ажиллагаанд стратегийн болон бодлогын түвшинд чухал нөлөө үзүүлсэн шийдвэрүүд байв.

7. *Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл*

Компанийн засаглалын кодексийн хэрэгжилт, түүний үнэлгээ

"Компанийн Засаглалын Кодекс"-ийг Санхүүгийн Зохицуулах Хорооны 2022 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 145 тоот тогтоолоор баталсан бөгөөд кодексийн хэрэгжилтийг жилд 2 удаа ТУЗ-ийн нарийн бичгийн дарга үнэлж, үнэлгээг зохицуулагч байгууллагаас хянан баталгаажуулдаг бөгөөд 2024 оны 3 дугаар сарын байдлаар Санхүүгийн зохицуулах хорооноос Ард Кредит ББСБ ХК-ийн Компанийн Засаглалын Кодексийн хэрэгжилт 87.5 хувийн гүйцэтгэлтэй гэж үзэн хянан баталгаажуулсан болно.

№	Агуулга	Авбал зохих нийт оноо	Үнэлсэн оноо	Үнэлгээний хувь
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	9	75.0%
2	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	7	70.0%
3	Тайлагнал, мэдээллийн ил тод байдал	6	6	100.0%
4	Аудит, хяналтын тогтолцоо	6	6	100.0%

5	Эрсдэлийн удирдлага	8	7	87.5%
6	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	4	66.7%
7	Оролцогч талуудын эрх ашиг	8	8	100.0%
8	Компанийн соёл	6	6	100.0%
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	10	100.0%
	Нэгдсэн дүн	72	63	87.5%

2025 оны эхний хагас жилийн байдлаар дараах тайлан мэдээллүүдийг холбогдох хууль, тогтоомжид заасан хугацаанд илгээж, олон нийтэд мэдээлсэн байна.

- 2024 оны жилийн санхүү болон үйл ажиллагааны тайлан;
- 2024 оны аудитлагдсан санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт;
- Компанийн Засаглалын кодексийн хэрэгжилтийн үнэлгээ;
- Комплаенсын эрсдэлийн үнэлгээний тайлан;
- 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын материал болон шийдвэр;
- Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоол;

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Г.Сүхбаатар
Албан тушаал: "Ард Кредит ББСБ"ХК-ийн Гүйцэтгэх захирал
Гарын үсэг: ……

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Г.Есү-Үжин
Албан тушаал: ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга
Гарын үсэг: ……